



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/184.

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ойг нөхөн сэргээх, үржүүлэх тарьц суулгацны зардалд 600,000 (зургаан зуун мянга) төгрөг, бичиг хэргийн зардалд 240,000 (хоёр зуун дөчин мянга) төгрөг, тендерийн баримт бичиг боловсруулах бичиг хэргийн зардалд 416,000 (дөрвөн зуун арван зургаан мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 840,000 (найман зуун дөчин мянга) төгрөгийг Байгаль хамгаалах сангаас 416,000 (дөрвөн зуун арван зургаан мянга) төгрөгийг Эрсдлээс хамгаалах сангаас тус тус зарцуулахыг сумын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН